



ТАВАНТОЛГОЙ ХХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИ

Өмнөговь, Цогтцэций сум, Утас: 7535-5555, 9500-1619
и-мэйл: info@tavantolgoi.mn

2024. 05. 06

№

1-449

танай _____ -ны № _____ -т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Шунхлай” ХХК-иас ирүүлсэн 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн В/807 тоот албан бичигтэй танилцаад дараах хариуг хүргүүлж байна.

- Тендерийн өгөгдлийн хүснэгтийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 18.2-т “Бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хий импортлох тусгай зөвшөөрөл, бүх төрлийн шатахуун, шингэрүүлсэн шатдаг хийн бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл” гэж заасан. Тус тендерийн нийлүүлэх барааны жагсаалтад шатдаг хий байхгүй. Иймд тус барааны тусгай зөвшөөрлийг хавсаргахгүй байж болох уу?” гэсэн дээр тодруулга өгөхөд манай худалдан авах барааны жагсаалтад шингэрүүлсэн шатдаг хий байхгүй тул хавсаргахгүй байж болох бөгөөд энэ нь үнэлгээнд нөлөөлөхгүй болохыг мэдэгдэж байна.
- Улсын бүртгэлийн гэрчилгээний үйл ажиллагааны чиглэл дээр “Гадаад худалдаа болон шатахуун импортлох, бөөний худалдаа болон жижиглэнгийн худалдаа эрхлэх”-ээр тусгасан байна. Манай компани нь бөөний болон жижиглэнгийн тусгай зөвшөөрөл, импортын тусгай зөвшөөрөлтэй бөгөөд улсын бүртгэлийн гэрчилгээнд тухай бүрд нь тэмдэглүүлдэггүй. Иймд тусгай зөвшөөрлийг хавсарган явуулах нь тендерийн баримт бичгийн шаардлагад нийцэх үү? гэсэн асуултад улсын бүртгэлийн гэрчилгээнд заавал байх шаардлагагүй бөгөөд бүх төрлийн шатахуун импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх хүчинтэй тусгай зөвшөөрлийг баримт бичигт ирүүлбэл шаардлага хангасан гэж үзнэ.
- Техникийн тодорхойлолт “Түлш шатахуун нь дараах стандартад нийцсэн байна. Багц-1 дээр Евро дизелийн түлш MNS 0216:2017 стандартын шаардлагыг тусгасан байна. Гэвч техникийн үзүүлэлт дээр K2 энгийн дизель түлш 6861:2020 стандартын шаардлагыг тусгасан байна. Экологийн ангилал – K2 гэж заасан байна. Аль бүтээгдэхүүнийг авахаа тодорхой болгож өгнө үү? гэсэн дээр манай компанийн техникийн тодорхойлолт дээр зөрүү гарсан тул K2 буюу энгийн дизель түлш авахыг үүгээр мэдэгдэж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.ГҮНЖДАГВА